



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/277

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 46 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ГААОНӨГ/202203060 дугаартай “108 сая мод тарих” төсөл арга хэмжээний хүрээнд Есөнбулаг сумын Баянхайрхан багийн 9 дүгээр гудамжны араар хашаа, хайс хийх ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Д.АЛТАНЗАГАС